

Төсвийн зөвлөлийг нэн даруй байгуулах шаардлагатай

ОУВС-гийн шинжээчид ирэх жилийн төсвийг анхааралтай ажиглаж байна. > 2

Эдийн засаг улс төрөөс үл хамааран идэвхжиж байна

Нүүрсний экспорт хэлбэлзэлтэй тул өөдрөг байхаас зайлсхийх хэрэгтэй. > 8



ОУВС 2017 оны дэлхийн өсөлтийн төлөвийг хэвээр үлдээв

Шведийн армийн нууц алдагдав



МССЕЖ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Банкны үйлчилгээ таны гарт.



NATIONAL NEWS CORP | БУРАГДЭХҮҮН КОМПАНИ

ubinfo.mn



МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.07.26, ЛИХАГВА ~ №138 (684)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч Элчин сайд Ж.Лантригай давхар татварын гэрээний талаар санал солилцов.

Кыргызийн Ерөнхий сайд тусгай элч илгээж, Ерөнхийлөгчийг албан ёсоор уриалаа.

ҮХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах УИХ-ын ТТ-ын Ажлын хэсгийг П.Цэрэн ахална.

СЕХ сонгуулийн зардлын тайлангаа ирүүлэхийг намуудаас шаардсан албан тоот илгээв.

Европын холбоо Монголд төлөөлөгчийн газраа нээхээр шийдсэнээ зарлажээ.

ЭДИЙН ЗАСАГ

"Оюутолгой" гурван сая дахь тонн зэсийн баяжмалаа тээвэрлэлээ.

Монгол Улсаас урд хөршийг чиглэх нүүрсний экспорт эхний хагаст 79.5 хувиар өсчээ.

"Urban Jeans" долоон сарын хугацаатай 420.5 сая төгрөгийн бонд гаргана.

"ДЦС-III" 57.1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллажээ.

Евро бүсийн эдийн засаг хоёрдугаар улиралд 0.6 хувиар өссөн байна.

НИЙГЭМ

Зөвшөөрөлгүй барьсан хашаа, байшингийн өргөтгөлийг албадан буулгажээ.

Өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангахыг хотын дарга ААН-үүдэд үүрэгдэв.

Эрээн хотод суух консулаар Ч.Амарболдыг томилохыг иргэд эсэргүүцлээ.

Сэлэнгийн Ерөө, Хүдэр сумдын хэд хэдэн багт ой хэзэрийн түймэртэй байна.

Булганд орсон мөндрийн улмаас учирсан хохирлыг эцэслэн тогтоогоогүй.

ДЭЛХИЙ

Польшийн сенат ЕХ-г үл ойшоон шүүхийн шинэчлэлийн тухай хуулийг баталлаа.

"Ноён Трамп Оросын эсрэг хоригийг цуцлахгүй" гэж Цагаан ордны төлөөлөгч мэдэгдэв.

Тайваньд гар утасны зай дэлбэрсний улмаас галт тэрэгний зорчигчдыг нүүлгэжээ.

Хойд Солонгос зургаа хоногийн дотор шинэ пуужин туршихыг CNN мэдээллээ.

АНУ-ын тусгай төлөөлөгч Украйнд зэвсэг нийлүүлэх боломжийг судалсан байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР


2017.07.26



25° | 11°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЭМ ГҮЙ МЭДЭЭЛИЙГ 6 ДУГААР НҮҮРГЭС ҮНШИНЭ ҮҮ




Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Дөрвөн жилд гурван сая тонн



"Оюутолгой" компани II улирлын тайлангаа шинэчлэн танилцууллаа. Үйлдвэр зэсийн баяжмалын экспортоо эхлүүлснээс хойш дөрвөн жил хүрэхгүй хугацаанд гурван сая дахь тонн баяжмалаа экспортлоод байна. ▶8

ЗГМ: ИНФОГРАФИК



Ubinfo.mn сайт шилдэгт багтлаа

"Засгийн газрын мэдээ" сонины цахим хуудас Ubinfo.mn нь Монголын мэдээллийн шилдэг сайтуудын долдугаарт бичигдлээ.

Эх сурвалж: Alexa.com

ЗГМ: ЗОЧИН

Монголд элэгтэй Ажиа Гэгээнтэний ээдрээт амьдрал

Соёлын хувьсгалаас шалтгаалж 10 гаруй жил тариа тарьсан

Г.Оюунтөгс @oyuuntugsZGM

Ажиа Гэгээнтэн бол Монголд элэгтэй хүн. Тэрбээр өөрийгөө дээд Монгол хэмээн үзэж, Монголд буяны үйлс бүтээж

яваа бидний ачтан. Энэ удаад тэрбээр мөн л буяны үйлс бүтээхээр, ЭХЭМҮТ-ийн дэргэдэх Хүүхдийн цусны эмгэг хавдрын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй хүүхдүүдийн бие хэрхэн илааршиж байгааг харахаар Монголд ирээд байна. Түүнийг энэ удаагийн "ЗГМ: Зочин" буланд урьж ярилцлаа. Тэрбээр өөрийн ээдрээт амьдрал болон хувьсгалын үед хэрхэн аж төрж байсан тухайгаа ярьсан юм.

▶4

ЗГМ: СЭДЭВ

Охидыг сэвтээсэн хүчирхийллийн сүүдэр

Б.Гандолгор @gandolgorZGM

Хөвдний түймэр шиг хэзээ ч унтардаггүй, нуугдмалаар газар авч байдаг зүйл бол гэр бүлийн хүчирхийлэл. Гэр бүлийн хүчирхийлэл зөвхөн Монголд бус бусад улс оронд ч тулгамдсан асуудалд тооцогддог. Манай улсад саяхан нэгэн жигшүүрт хэргийг илрүүлсэн байна. Өсвөр насны

хоёр дагавар охиноо дөрвөн жилийн турш хүчирхийлж байсан хойд эцгийн хэрэг өдгөө хуулийн байгууллагад шилжээд буй. Том охин нь хойд эцгийнхээ хүүхдийг гэжж байгаа аж. Мөн 13 настай дагавар охиныхоо биенийг хүчээр үнэлүүлж, орой гэртээ харихад нь гарыг хутгаар зүсэж яргалдаг байсан гэж үйлдлийг ч төрийн бус байгууллагынхан илрүүлжээ.

▶5

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Төрөөр чөдөрлүүлсэн төмөр зам

Г.Байгал @baigalZGM

Данс улайж, ханш "халж" байсан өнгөрсөн оны долдугаар сард төрийн эрхийг авсан хүнд үетэй харьцуулахад өдгөө Засгийн газар амьсгаа авахаар болжээ. Өндөр шаардлагатай ч гэсэн ОУВС-тай түншилж, үе шаттай ч гэсэн зургаан тэрбум ам.доллар Монгол Улсыг чиглэхээр болж байна. Энэ мөнгөний урсгал манай төлбөрийн тэнцлийг ундаалж, төсвийн цоорхойг нөхнө. Ингэснээр гацаасан төслүүдээ урагшлуулах санхүүгийн чадамж, хөгжлийн далавч Засгийн газарт бий болох юм. Уг нь санхүүгээ шийдэж чадвал энэ засаг улс төрийн ялгуусан ялалтын нөмөрт багтаж буй. Намуудын талцал, унагачих болов уу гэсэн улс төрчдийн хайчин дундуур туучилгүй, итгэл төгс урагшлах таатай талбар бүрдээд байна.

Тиймээс өнгөрсөн жилүүдэд улс төржилтийн бай болсон төслүүдээ хөдөлгөж, эдийн засгаа сэвхийтэл босгоод ирэх болов уу гэж иргэд горьдлого тээсэн харцаар харж сууна.

▶3

MSE ALL

884.42
0.31%

АЛТ

1250.40
0.37%

ЗЭС

6027
0.38%

10-ЧИНГИС БОНД

96.360
0.21%

5-ЧИНГИС БОНД

100.470
0.11%

АМ.ДОЛЛАР

2424.68

ЮАНЬ

359.17

РУБЛЬ

40.55

Улс төр

ТӨСӨВ

Төсвийн зөвлөлийг нэн даруй байгуулах шаардлагатай



Б.Ганбаяр / ЗГМ©

ОУВС-гийн шинжээчид ирэх жилийн төсвийг анхааралтай ажиглаж байна

Б.Бямбасүрэн
@byambaZGM

Монгол Улс ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлээд хоёр сарын хугацаа өнгөрч байна. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд хэд хэдэн зорилт дэвшүүлж, шаардлага тавьсны нэг нь Монгол Улс төсвийн зөвлөл байгуулах үүрэг хүлэсэн юм. Тэрчлэн хөтөлбөр хэрэгжих гурван жилийн хугацаанд улирал тутам Сангийн яам, Монголбанк, Валютын сан хамтран үр дүнгийн шалгалт хийж, үнэлгээ өгөхөөр тохиролцсон. Гэвч хоёр сарын хугацаа өнгөрчихөөд байхад Төсвийн зөвлөлийг одоо хэр нь

байгуулаагүй байна. Мөн ОУВС-гийн шинжээчид Монгол Улсад үнэлгээ хийхээр ирсэн энэ үед Төсвийн зөвлөл байгуулаагүйгээр үл барам хүүхдийн мөнгөнд 48.4 тэрбум төгрөг зарлагдсан нь дараагийн санхүүжилтийг авахад бэрхшээл дагуулж мэдэхээр байгааг эдийн засагчид ярьж байна.

Хамгийн гол нь намрын чуулганаар нэн тэргүүнд Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Энэ үед Төсвийн зөвлөл улсын төсвийн боловсруулалт, зарцуулалтад хяналт тавих, алдагдалгүй төсөв батлуулах үүрэгтэй. Засгийн газар 2017 оны төсвийн тодотголыг өргөн барихдаа орлогыг зургаан их наяд төгрөг буюу ДНБ-ий 23.2 хувь, нийт зардал 8.7 их наяд төгрөг буюу ДНБ-ий 33.6 хувь байхаар тооцсон. Харин нэгдсэн төсвийн

нийт тэнцвэржүүлсэн алдагдал 2.7 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 10.4 хувьтай тэнцэхээр төсөөлсөн. Ийнхүү алдагдалтай төсөв баталж, үүнээсээ ч хэтэрсэн алдагдалтай гүйцэтгэлтэй гараад байна. Иймд 2018 оны төсвийн тухай хуулийн төслийг ОУВС-гийн шинжээчид анхааралтай ажиглаж байгаа энэ үед Төсвийн зөвлөл ирэх жилийн төсвийг алдагдалгүй төлөвлөх ёстой хэмээн эдийн засагчид үзэж байна.

Хууль боловсруулагчид өөрийн тойрогт аль болох илүү мөнгө хуваарилахын тулд төсвийг данхгар бүтэцтэй болгодог нь нууц биш. Өөрөөр хэлбэл, УИХ төсөв батлах үеэр УИХ-ын гишүүн бүр санал гаргаж, шаардлагагүй зардал нэмэгдүүлэх тохиолдол олон гардаг. Тиймээс зөвлөл байгуулснаар УИХ-ын гишүүд өргөн барьсан төсвийн

төсөлд дураараа өөрчлөлт оруулдаг байдлыг зогсоох давуу талтай. Энэ мэтчилэн үргүй зардал таналт хийж, аль болох алдагдал багатай төсөв баталж, эдийн засгаа эрүүлжүүлэх нь Монгол Улсын өмнө тулгамдсан асуудал болоод буй.

Одоогоор Төсвийн зөвлөлийг ямар бүтэц, бүрэлдэхүүнтэй байгуулах шийдэл хараахан гараагүй байна. Харин намар буюу 2018 оны төсвийн төслийг хэлэлцэхээс өмнө Төсвийн зөвлөлийг байгуулахаар төлөвлөнгийг албаныхан хэлж буй. Иймд УИХ, Засгийн газрын дэргэд төсвийн мэргэжлийн институт байгуулах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, УИХ, Байнгын хороо төсөв хэлэлцэж байх үед боловсруулсан төсөвт тусгаагүй зардал нэмэх, байшин барилга, хүүхдийн мөнгийг нэмье зэрэг санал гаргахад зөвхөн

байнгын хорооны гишүүд дур мэдэн шийдэх нь бий. Үүний оронд тухайн саналыг Төсвийн зөвлөлд багтсан мэргэжлийн баг судалж, аль зардлыг нэмж, алийг нь бууруулах талаар дүгнэлт гаргадаг болно гэсэн үг. Төсөв батлах, хэрэгжүүлэх үед УИХ-ын Төсвийн байнгын хороонд зөвлөх мэргэжлийн зөвлөл ажиллана. Түүнчлэн манай улс түүхий экспортод хэт найддаг, төсвийн орлогыг тооцоо судалгаагүй өөдрөгөөр төсөөлснөөс болж жил бүрийн орлого өндөр хувиар тасалдаж ирсэн. Тиймээс цаашид эрдэс бүтээгдэхүүний экспортын үнэ, орлого, зарлагыг бодитой төлөвлөхөд Төсвийн зөвлөлийн санал дүгнэлт чухал байр суурьтай байх юм. Хамгийн чухал нь Төсвийн зөвлөл санхүүгийн сахилга батыг сайжруулах учиртай. [ЗГМ]

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Европын холбоо Бүрэн эрхт төлөөлөгчийн газраа нээнэ

З.Цэлмэг
@telmegZGM

Европын холбооны гадаад харилцаа, аюулгүй байдлын бодлого хариуцсан дээд төлөөлөгч, Европын комиссын дэд ерөнхийлөгч Федерика Могериний шийдвэрийг үндэслэн Монгол Улсад Европын холбооны Бүрэн эрхт төлөөлөгчийн газар нээхээр болжээ. Ингэснээр дэлхийд Европын

холбооны төлөөлөгчийн газрын тоо 140 болж буй юм.

Европын комиссын Ерөнхийлөгч Жан Клод Юнкер “Европын холбоо Монголд Бүрэн эрхт төлөөлөгчийн газраа нээх амлалтаа биелүүлж байна. Монгол бол ОХУ, БНХАУ-ын дунд оршдог стратегийн байршилтай, бидний хувьд чухал түнш юм. Би Монгол Улсад гурван удаа айлчилсан. Анх 1998 онд очиж байсан бол хамгийн сүүлд 2016 онд зочилсон. Энэ улс

гайхалтай хөгжиж, дэвшсэнд чин сэтгэлээсээ баяр хүргэж байна. Европын Холбооны байнгын төлөөлөгч байх хэрэгтэй” хэмээн онцолсон байна.

Харин дэд ерөнхийлөгч Федерика Могерини “Төлөөлөгчийн газар нь Монголтой харилцаагаа зузаатгахад оруулж буй Европын холбооны нэг хөрөнгө оруулалт, ард түмнийх нь өмнө хүлээсэн үүрэг юм. Түншлэл, хамтын ажиллагааны шинэ гэрээ удахгүй байгуулна.

Энэ бол ойр дотно харилцаагаа цаашид хөгжүүлэхийн ач холбогдлыг илтгэж буйн хэрэг” хэмээжээ.

Улаанбаатарт Бүрэн эрхт төлөөлөгчийн газар байгуулснаар талууд улс төрийн яриа хэлэлцээ, хамтын ажиллагаагаа нэг шат ахиулах боломжтой болох бөгөөд түншийн харилцааг сайжруулахад чухал алхам болно хэмээн Европын комиссын албан ёсны цахим хуудаст нийтэлжээ. [ЗГМ]

ЭШЛЭЛ



Манай нам анхнаасаа Үндсэн хуульд өөрчлөлт оруулах бус шинэ Үндсэн хууль бүтээх ёстой гэсэн байр суурь барьж, Үндсэн хуулийн төслийг 10-аад жилийн өмнө хэлэлцүүлж байсан. Одоо ч гэсэн Үндсэн хуулийн шинэчлэлд хандахдаа өөрчлөлтийн хүрээгээ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд баригдалгүй шинээр тогтоож, хуульчлах нь чухал. Мөн хууль өөрчлөх, шинэчлэх зарчмаа тогтоох, аргачлалаа тодорхойлох, эцэст нь механизмаа тохирох гэсэн шат дараалсан хэдэн алхам байх ёстой гэж үздэг. Гэхдээ гол чиглэл баримжаа болгон хэлэлцүүлж өрнүүлэхэд болохгүй зүйлгүй. Энэ хүрэнээс давж гарсан саналуудыг Ажлын хэсгүүд УИХ-д оруулж хэлэлцүүлэх шаардлагатай.

МУАН-ын дарга
Б.Цогтгэрэл

ЗГМ ТОВЧХОН

» **ЕРӨНХИЙЛӨГЧ**
Ерөнхийлөгч Х.Баттулгад Австралийн холбооны улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ж.Лантри бараалхав. 2017 оны байдлаар Монгол Улсаас Австралид 2000 орчим оюутан суралцаж байгаа аж. Энэ үеэр хоёр тал бизнесийн харилцаагаа өргөжүүлэх, давхар татварын гэрээг хэрэгжүүлэх болон бусад чиглэлээр хамтарч ажиллахаар санал солилцлоо.

Мэргэжлийн сүмогийн 69 дэх их аварга, Хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин Хакүхо М.Даваажаргал эцэг, эхийнхээ хамт Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхлаа. Тэрбээр сүмогийн түүхэнд хамгийн олон буюу 1047 даваа авсан озэки Кайогийн амжилтыг эвдэж 1050-д хүргэсэн. Дээд зиндааны 39 дэх түрүүгээ авч, өөрийн амжилтыг улам ахиулсан түүнд Ерөнхийлөгч Х.Баттулга баяр хүргэв.

» **УЛСЫН ИХ ХУРАЛ**
Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулахад туслалцаа үзүүлэх Тамгын газрын Ажлын хэсгийг УИХ-ын Тамгын газрын Захиргаа, аж ахуйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга П.Цэрэнгээр ахлуулан байгууллаа. Ажлын хэсгүүд аймаг, орон нутагт энэ сарын 31-нээс наймдугаар сарын 28-нд, нийслэлд энэ сарын 15-31-нд ажиллах юм.

» **СОНГОЛТ-2017**
Сонгуулийн тухай хуульд зааснаар Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын тайлан гаргаж, СЕХ-нд хүргүүлэх үүрэгтэй. Энэ дагуу нэр дэвшигчид энэ сарын 26, намууд ирэх сарын 10-ны өдөрт багтаан тайлан ирүүлэх ёстой аж.

» ТОО

37.8

Тэрбум. 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 3778 эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн бол гэмт хэргийн улмаас нийт 37.8 тэрбум төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирчээ.

» ШААРДЛАГА

Өмгөөлөгч Г.Баасан 60 тэрбумын тухай 90 минутын бичлэгийг шинжилгээний байгууллагаар шалгуулахыг хүсч байгаагаа илэрхийллээ.

» ШАЛГАРУУЛАЛТ

Шүүгчийг сонгон шалгаруулах журмын дагуу эрүү, иргэний хэргийн шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтын суурь шалгалтыг зарлажээ. Сонгон шалгаруулалтад оролцогчдын материалыг энэ сарын 21-нээс хүлээн авч байна.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZASAG.CO

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ
сонин ХМХ

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шуудагга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатар ДӨЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Баатарын Дуламхорлоо

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртгогтох
Утас: 99901532

Гадаад контент, соёл энтертайнментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Э.Энхбаатар
Утас: 99903578

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР
ubinfo.mn

Дугаарын удирдагч
Б.Баярмаа

ЯГ ОДОО УТСАНДАА СУУЛГААРАЙ

ubinfo.mn

МОНГОЛД ХАМГИЙН ИХ АШИГЛАГДАГ ГАР УТАСНЫ АПП UB INFO

ТА ХОЦРООГҮЙ БИЗ?

Нийтлэлчийн булан

Эдийн засагт хамгийн хурдан өгөөжөө өгөх төсөл нь өмнөд бүсийн төмөр зам

“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн дэмээр санхүүгийн чадамжтай болох энэ Засгийн газрын эдийн засгаа тэтгэх эхний “хөзөр” нь юу бол. Өнгөрсөн есдүгээр сард УИХ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр баталсан. Уг жагсаалтад багтаасан ажлуудыг эхнээс нь хэрэгжүүлэх байх гэсэн хүлээлт бий. Гэхдээ маш богино хугацаанд өгөөжөө өгч, Монголын эдийн засагт мэдэгдэхүйц сэргэлт авчрах, гарт баригдаж, нүдэнд үзэгдэх ямар төслийг Засгийн газар зориг гаргаж, ханцуй шамлан

Монголын эдийн засагт ус, агаар мэт хэрэгтэй энэ төслийг Засгийн газрын яамд бие бие рүүгээ бичиг шидэлцэн “хэрэгжүүлж” байна.



Б.Ганбаяр / ЗГМ

Төрөөр чөдөрлүүлсэн төмөр зам

хэрэгжүүлэх вэ. Одоогоор үүнийг ингэж хэрэгжүүлнэ гэдгээ зарлаад буй тодорхой төсөл, хөтөлбөр тун цөөн байна. Боловсруулах үйлдвэрүүдийг хөдөлгөхөө мэдэгдсэн ч эдгээр аварга төслийн өгөөжөө өгөх хугацаа нь дор хаяж 5-6 жил. Энэ хүртэл хүлээж, бид нефть нэрж, зэс хайлуулан, орлого олно. Тэгэхээр цаг хугацааны хувьд хамгийн ойр, үр өгөөжийн хувьд бага биш төсөл, хөтөлбөрийг сонгох, түүнийг түргэсгэх шаардлага тулгараад байна.

Дэлхийн зах зээл, дотоодын бодит боломжийг тооцоод үзвэл богино хугацаанд доллар даллах төсөл нь “Алт” хөтөлбөрөөс гадна өмнөд бүсийн төмөр замын төслүүд гэдгийг эрдэмтэн, судлаачид олон жил хэлж байгаа. Ялангуяа, манай нүүрсний гол суваг болох Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам эдийн засгийн хүндрэлийг даван туулах, хөгжилд хүрэх эхний гүүр болохыг шинжээчид онцолж байгаа юм.

Учир нь энэ төсөл Монголын нүүрсний салбарт үсрэлт авчирна гэхэд хэлсэдхгүй. Тиймээс тэрбум гаруй ам.доллараар хэмжигдэж буй энэ төсөл сүүлийн найман жил халуун сэдэв болж, дуулиан шуугиан дагуулсаар байна. Тавантолгойн төмөр замын маргааныг түр орхиё. Харин илүү ажил хэрэгчээр харах гээд оролдъё. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн

төмөр зам Монгол Улс дэлхийн коксжих нүүрсний хүчирхэг тоглогчдын нэг болоход дэмжлэг үзүүлнэ. Учир нь түүхий эдийн нөөцөөрөө дэлхийд эхний 10-т эрэмбэлэгддэг Тавантолгойн коксжих нүүрсийг Хятадын хил хүргэх гол зам нь энэ юм. Тиймээс нүүрсний салбарт төдийгүй Монголын эдийн засагт үлэмж нөлөөтэй. Гэтэл Хятадын тал Монголын хил хүрсэн төмөр замаа тавьчихаад найман жил биднийг хүлээж байна. Харамсалтай нь Монгол Улс төмөр замаа хил хүргэж чадалгүй энэ олон жилийг үдсээр.

Монголын нүүрсний гол шугам болох учиртай энэ замын ажил 2015 оны нэгдүгээр сард гасан. 51 хувийн гүйцэтгэлтэй хоёр жилийг үдэж байна. 200 гаруй километр энэ замын суурийн ажил 86 хувьтай байгааг салбарын яамнаас мэдээлсэн. Уг нь энэ төслийн талаас илүүг нь нугалчихсан тул их удлаа гэхэд хоёр жилийн дотор төмөр зам тавих боломжтой. Гэхдээ урьдаад шийдлээ хүлээж буй хэд, хэдэн зангилаа бий. Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх Н.Энхбаяр “Барьж эхлээс өмнө шийдэх ёстой асуудал бий. Хоёр улсын төмөр замын уулзах цэг зөрсөн. Үүнийг шийдэхгүйгээр дараагийн ажлыг эхлүүлэх боломжгүй. Мөн гүйцэтгэлийг нь дахин сонгон шалгаруулна. Зам, тээврийн хөгжлийн яаманд гүйцэтгэгчээ сонгон шалгаруулж,

ирэх намар гэхэд тодорхой болно” гэж мэдээллээ.

Хятад, Монголын хил дамнах энэ төмөр замын уулзах цэг зөрсөн тул урд хөршийн Ганцмодны боомт хүртэл нэмж 25 километр төмөр зам тавих шаардлага үүсээд байгаа юм. Үүнд багаар бодоход 100-150 сая ам.долларын санхүүжилт хэрэгтэй гэсэн тооцоо гарсан. Зөрүүг нийлүүлж, нэмж зам тавихын тулд зураг төслийг засварлан, зураглалыг нь бэлэн болгох хэрэгтэй байгаа юм. Иймд хил нэвтрэх цэгийг тохирохын тулд Хятадын талтай дахин хэлэлцэх учиртай. Тиймээс Гадаад харилцааны яаманд энэ чиглэлийн албан бичиг хүргүүлсэнэ Зам, тээврийн хөгжлийн яам мэдээллээ.

Урд хөрштэй тохирч, зураг төслийг нь бэлэн болголоо гэхэд ямар хөрөнгөөр барих нь өнөөг хүртэл бүүдгэр хэвээр байна. Ажлын талыг нь хийчихсэн энэ замд дахин 1.1 тэрбум ам.долларын санхүүжилт хэрэгтэй байгааг мэргэжлийн байгууллага мэдээллээ. Нэгэнт төр хэрэгжүүлэхээ мэдэгдэж, хувийн хэвшилээ буцаан авсан тул санхүүжилтээ хариуцаж таарна. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгаснаар уг замыг Хятадын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр заажээ. Энэ

замыг санхүүжүүлэхээр Сангийн яам хэд хэдэн хувилбар боловсруулж байгаа аж. Зам, тээврийн хөгжлийн яамнаас хөрөнгө оруулалтыг нь шийдэж өгөхийг хүссэн хэд, хэдэн албан бичиг хүргүүлсэн байна.

Гэхдээ одоогоор ийм санхүүжилтээр ингэж шийднэ гэсэн тодорхой мэдээлэл алга байна.

2009 онд Тавантолгой-Гашуунсухайт, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замыг бие даан барих зөвшөөрлийг “Энержи Ресурс”, МАК-д өгчээ. Гэвч 2012 онд төр энэ зөвшөөрлөө авч, өөрөө хэрэгжүүлэхээр болсон юм. Харамсалтай нь хэрэгжүүлнэ гээд хураан авсан төслөө гүйцээгүй хэдэн жилийг үдэж байна. Төр хамгийн муу менежер гэдгийг илтгэдэг олон жишээний нэг нь энэ. Төслийн эрхийг хувийн хэвшилээ булааж авсан төр одоо ямар нэг аргаар хөрөнгө мөнгө олж, төмөр замаа урагшлуулах учиртай. Хэдийгээр Засгийн газар экспортын дэд бүтцийг дэмжинэ гэдгээ мэдэгдээд байгаа ч үнэндээ өмнөд бүсийн төмөр замыг ингэж эхлүүлнэ гэсэн тодорхой гаргалаа алга л байна. Яамдууд бие бие рүүгээ албан бичиг шидэлцээр энэ мэт хэдэн жилийг үдэх магадлалтай.

Биднийг ийн суух зуур нүүрсний үнэ өсөж, олох боломжтой ахиу орлого Монголыг тойрсоор. Өнгөрсөн жилүүдэд алдсан боломжийн талаар ярихад эндүү оройтсон ч дэлхийн зах зээлээс

Монголд олгосон шар тосоо бид өөрсдөө хэлээрээ түлхэж орхисон. Төмөр зам тавиагүйгээс өнгөрсөн таван жилд Монгол Улс нүүрсний экспортоос гэхэд бараг 10 тэрбум ам.доллар алдсан гэх судалгааны дүн бий. Хэрэв 2009 оны үед дээрх төмөр замыг төр биш хувийн хэвшил тавьж, 2012 онд дуусгасан бол өнгөрсөн таван жилд багаар бодоход жилд 20 сая

тонн угаасан нүүрсийг нэмж экспортлохоор байв. Ингэхээр таван жилд 100 сая тонн нүүрс болох бөгөөд тонныг нь 100 ам.доллараар борлуулна гэж тооцвол 10 тэрбум ам.доллар алдчихаад байна. Энэ бол Монголын нийт эдийн засагтай дүйх дүн. Төмөр зам Монголын хөгжлийг түргэсгэнэ гээд буйн шалтгаан нь энэ.

Монгол Улс өнгөрсөн онд 25 сая тонн нүүрс хилийн чанадад нийлүүлсэн нь түүхэн дээд үзүүлэлт боллоо хэмээн бид алга ташаад л сууж байна. Гэтэл манай хил орчмын нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг тооцоод үзвэл 50 сая тонныг давдаг. Өөрөөр хэлбэл, бид бодит боломжийнхоо ердөө тал хувийг ашиглачихаад, баярлан дэвхцэж байна. Хэрвээ төмөр замтай байсан бол одоогийн тээврийн зардлаас 4-5 дахин хямд үнээр, хүчин чадалдаа хүрсэн хэмжээгээр нүүрсээ экспортлож чадах байлаа.


Үүнээс үзэхэд, хүссэн, хүсээгүй Монголын эдийн засгийн ирэх хэдэн жилийн хөгжлийг төмөр зам тодорхойлохоор байна. Гэвч Монголын эдийн засагт ус, агаар мэт хэрэгтэй энэ төслийг Засгийн газрын яамд хайхрамжгүй байдлаар бие бие рүүгээ бичиг шидэлцэн, “хэрэгжүүлж” байна. Энэ чиглэлд тодорхой, зоригтой удирдлага үгүйлэгдэж байна. Эс бөгөөс замгүй Монголын зовлон дахиад л үргэлжлэх нь. [ЗГМ]

» Ялангуяа, манай нүүрсний гол суваг болох Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам Монголын эдийн засгийн хүндрэлийг даван туулах, хөгжилд хүрэх эхний гүүр болохыг шинжээчид онцолж байгаа юм.

» Хятадын тал Монголын хил хүрсэн төмөр замаа тавьчихаад найман жил биднийг хүлээж байна. Харамсалтай нь Монгол Улс төмөр замаа хил хүргэж чадалгүй энэ олон жилийг үдсээр.

» Хэрвээ төмөр замтай байсан бол 4-5 дахин хямд зардлаар бүрэн хүчин чадлаараа нүүрс экспортлож чадах байлаа.

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



ЗГМ: Зочин

«**Та Монголд ямар зорилгоор айлчилж ирсэн бэ?**

-Хүүхдийн цусны эмгэг, хавдрын эмнэлгийн эмчилгээ хүүхдүүдэд ямар үр дүн үзүүлж байгааг харахаар АНУ-аас ирээд гурав хонож байна. Хүүхдийн шүдэнд эмчилгээ хийж, зөвлөгөө өгөхөөр Япон улсаас, хөнгөвчлөх эмчилгээний талаар сургалт явуулахаар АНУ-аас эмч нарыг урьсан нь Монголд ирэх бас нэг шалтгаан болсон. Түүнчлэн Яармагт өндөр настан, хүүхдэд зориулсан буян хийхээр ирсэн. Гэхдээ яг юу хийхээ шийдээгүй л байна.

-Хэзээ хамгийн сүүлд Монголд ирсэн бэ. Өөрчлөгдсөн зүйл хэр их байна вэ?

-Монголд анх 2006 онд ирж байлаа. Үүнээс хойш жил бүр ирдэг болсон. Өмнө нь Цагаан сарын үеэр ирэхэд маш их утаатай байсан. Харин энэ удаа утаагүй, сайхан санагдаж байна. Маш олон өндөр барилга баригдсанаас гадна машины жолооч нар соёлтой, эмх цэгцтэй болжээ. Улаанбаатарт жил бүр шинэ барилга баригдаж, орчин өөрчлөгдөж байгаа. Гэхдээ

Улс төрийн хувьсгал өргөн хүрээтэй байсан болохоор сүм хийдэд суудаг миний хувьд сургуульд явж, эрдэм сурах завшаан олдоогүй.



Б.Ганбаяр / ЗГМ©

Монголд элэгтэй Ажиа Гэгээнтэний ээдрээт амьдрал

үүнээс илүү хөгжих ёстой гэж би боддог. Учир нь Монгол орон өргөн уудам нутагтай, эрх чөлөөтэй, сайхан орон шүү дээ.

-Та өөрийгөө монгол хүн гэдэг. Төрсөн нутаг, бага насныхаа талаар ярихгүй юу?

-Би монгол гэрт төрсөн монгол хүн. 1950 оны есдүгээр сарын 21-нд Төвөдийн хамгийн үзэсгэлэнт газар болох зах хязгааргүй үргэлжилдэг ногоон хивс дэлгэсэн мэт өргөн уудам талд, өнгийн цэцэгс алагласан Долоон нуурт 11 хүүхэдтэй жирийн малчин айлын ес дэх хүү нь болон мэндэлсэн. Ингээд 1952 оны зуны дунд сард Гүмбүм хийдийн эзэн ламын хойд дүрийг тодруулах эрлийн баг Гүмбүм хийдээс хөдөлж, жилийн турш хайж, шинжсээр ирсэн гэдэг. Тухайн үед эрэлчид увидастай хүүхэд төрсөн айлын гэр дээгүүр солонго татсан онцгой үзэгдлийг тандахаас гадна эзэн ламын эд зүйлсийг таних, эсэхийг нь шалгаж байсан. Ингээд удалгүй эрэлчид дөрөө мултлахад аав угтан гарч, гэртээ залахад настай хувраг босож, энх мэндийн цагаан хадаг дэлгэн аав, ээжийн хүзүүнд тохож “Төвөдийн бурхан шашны Гэлүгба уламжлалыг үндэслэгч Богд Зонхавын аавын VIII дүрийг төрүүлсэнд баяр хүргэе” гэсэн гэдэг. Гүмбүм хийдэд монгол лам нар их бий. Нагац маань миний чухам ачтай багш. Энэ хүн маань бас монгол хүн. Тиймээс надад монгол хүний төлөө гэсэн сэтгэл байдаг.

-Таныг АНУ-д цагаачлахаар очсон гэж дуулсан. Энэ тухайгаа ярихгүй юу?

-Би 1998 онд улс төрийн асуудлаас болоод нутгаасаа гарч, АНУ-д цагаачилсан. Тухайн үед төрсөн нутаг, гэрээ санаж хэцүү байхад Шичинбаатар гэдэг найз маань Монголд ирэхийг санал болгосон юм. Ингээд Монголд ирж, Улаанбаатарт байдаг бүх хийдэд очиж мөргөсөн.



Хувийн архиваас©

Хамгийн гол нь Монголын онгон дагшин байгаль, хөдөө нутагт очиход төрөлх нутагтаа ирсэн мэт үнэхээр сайхан санагддаг. Багадаа монгол гэрт амьдардаг байсан болохоор цай чанах, дээж өргөх зэрэг монголын ёс, уламжлалыг хараад сэтгэл үнэхээр их хөдөлсөн. Үүнээс хойш Монголд ирэх дуртай болсон доо. Харин одоо АНУ-ын Индиана мужийн Блүүмингтон хотод байрладаг Төвөд-Монголын шашин соёлын төвийн тэргүүнээр ажиллаж байна.

-Гэгээнтэнээр тодорсон хэдий ч соёлын хувьсгалын салхи таныг дайраад гарсан гэдэг. Тухайн үед нөхцөл байдал ямар байсан бэ?

-Би 1950 онд төрсөн. Тухайн үед миний төрсөн нутаг Гүмбүмийг Хятад эзэлсэн хэдий ч сүм хийдэд гар хүрээгүй юм. Харин 1958 оноос хөдөлгөөн

ширүүсч, сүм хийдийг хааж, лам хуврагуудыг барьж шоронд хийсэн. Үүнээс хойш байдал улам хурцдаж, соёлын хувьсгал болсон. Тухайн үед би хувьсгалаас болж, 10 гаруй жил тариа тарьж, завсар чөлөөгүй ажилласан даа. Ингээд 1980 оноос Хятадын бодлого арай зөөлөрч, сүм хийдийг сэргээсэн. Гэсэн ч тухайн үеийн коммунист засаг их хүнд байсан нь одоо ч хэр нь санаанаас гардаггүй юм.

-Таны залуу нас хөдөлмөрийн лагерт өнгөрч, басхүү хүнд бэрхшээлтэй замыг туулсан байх нь.

-Улс төрийн хувьсгал өргөн хүрээтэй байсан болохоор сүм хийдэд суудаг миний хувьд сургуульд явж, эрдэм сурах завшаан олдоогүй. Нагац ах маань намайг ажил хийж зовж зүдэрч байгаа хэдий ч нууцаар ч болтугай эрдэм сурах хэрэгтэй

гэсэн. Ингээд л бичиг үсэг, ном сурах ажилд шамдсан. 1970 он гарснаас хойш их сургуульд хоёр ч удаа явсан. Өөрөө мэрийж байгаад эрдэм сурсан шүү. Би архитектор, зураг зурахад их дуртай. Тийм болохоор энэ талаар бага сага мэдлэгтэй болсон. Цаг үе хэцүү байсан ч энгийн амьдралаар амьдрах сайхан байсан шүү.

-Төрөлх нутгаа их санагалздаг байх. Ах дүү нартайгаа холбоотой байдаг уу?

-АНУ-д ирээд эхний хоёр жил гэр бүлийнхэн, эх нутгаа их санаж, бэтгэрсэн. Ээж минь өөд болоод 30 гаруй жил болж байна. Харин аав минь 1958 онд Хятадын хувьсгалын хөдөлгөөнөөр баригдсан. Түүнийг миний буюу гэгээнтэний аав учраас барьж, хорьсон. Хөөрхий аав минь тэндээ өөд болсон. Нутгаасаа гараад удсан болохоор сүүлдээ гэрээ санахаа больж, байгаа орчиндоо дасчихдаг юм байна. Харин ах дүү нар маань нутагтаа байгаа. Улс төрийн зорилгоор утас чагнадаг болохоор нэг их холбогддоггүй. Бүр зориуд зав гарган хааяа ах дүү нартайгаа аж амьдрал, эрүүл мэндийг нь асууж ярьдаг даа.

-Та Монголоос өөр улсад хүмүүнлэгийн тусламж үзүүлдэг үү?

-Би бол дээд монгол хүн. Тиймээс Монголдоо илүү сэтгэлтэй. Гэхдээ ямар ч улсын хүн байсан адилхан шүү дээ. Тиймээс их бага хэмжээгээр боломжийнхоо хэрээр хандив өргөдөг. Тухайлбал, миний бие Монгол-Төвөд хүн учраас Энэтхэгт улс төрийн асуудлаар цагаачилсан хүмүүст туслахын тулд номын сан, сургууль, хоол хүнс зэрэгт зориулан хандив өргөдөг. Мөн хэдэн жилийн өмнө Японд цунами болоход хандив цуглуулж, хэд хэдэн удаа өөрийн биеэр очиж өгсөн. Харин саяхан “Ид шидийн орон” гэх сайн үйлсэд жаахан ч гэсэн буян үйлдсэн. Чухамдаа саад, бэрхшээл тулгарсан бүхий л газарт очиж, хандив өргөхийг боддог. Мөн их, дээд сургуулиудад хичээл заадаг. Тухайлбал, хэдэн жилийн өмнө Английн Оксфордын их сургуульд бурхан шашны тухай хичээл заасан. Зочин профессорын хувиар Индианагийн их сургуулийн урилгаар хичээл заадаг.

-Таныг Хүүхдийн цусны хорт хавдрын эмнэлэг барьж өгсөнд монголчууд маш их талархдаг. Хөрөнгө мөнгөний хувьд бэрхшээл их гарсан уу?

-Анх 2011 оноос хандив цуглуулж, эмнэлэг барихаар

төлөвлөж байлаа. Тухайн үед хөрөнгө мөнгө, эмнэлэг барих газар байгаагүй учраас түр хойшлуулсан. Ингээд эмнэлэг барих талаар гадаадад болон Монголд байгаа хүмүүст дуулгахад “тусалъя” гэж хэлсэн. Үүнийг сонсоод сэтгэл санаа их сайхан болж, эмнэлгээ барьж эхэлсэн дээ. Тухайн үед зарим нэг бэрхшээл гарч тулгарсан. Хөрөнгө мөнгөний хувьд ч хэцүү байсан. Гэхдээ нэгэнт эхэлсэн ажил учраас дуусгахын тулд зүүтгэхэд “тусалъя” гэж хэлсэн. Сингапур, Япон, АНУ, Хятадад байдаг шавь нар маань нэлээд хэмжээний хандив цуглуулж өгсөн. Зөв зүтг харсан, их буян учраас энгийн малчнаас эхлээд багш, эмч гээд олон хүний сэтгэл, зүтгэлээр эмнэлэг маань боссон юм шүү. Харьд байгаа ч гэсэн монголчууд нутагтаа ээлтэй, элгэмсэг хүмүүс. Хөрөнгө мөнгөнөөс илүү сэтгэлийн тус их байсан гэж боддог.

-Цаашид Монголд хийхээр төлөвлөсөн зүйл бий юу?

-Одоогоор төлөвлөсөн юмгүй байна. Гэхдээ буяны ажил хийх завшаан гарвал хөдөөнөөс хот руу нүүдэллэх хүмүүс их болсон учраас эмнэлэг, эсвэл сургууль барина гэж төлөвлөж байна.

-Ярилсанд баярлалаа. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017-07-26

Тендер шалгаруулалтын нэр: **ТА №3-н туслах тоноглолын их засварын ажил**Тендер шалгаруулалтын дугаар: **T-2017-06/01**

“ДЦС-4”ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос: **ТА № 3-н туслах тоноглолын их засварын ажил гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.**

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 100,000 төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалт нь тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх /2015, 2016 он /

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **сүүлийн 2 жил**

/2015, 2016 он /

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх

/2015, 2016 он тус бүрээр /

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: тусгай зөвшөөрөл шаардлагатай.

Тендерийн хамт тендерт санал болгосон үнийн дүнгийн 2%-аас багагүй дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 08 дугаар сарын 28-ны 10.00 цагаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 08 дугаар сарын 28-ны 10 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо. “ ДЦС-4” ТӨХК. Захиргааны II байр 2 давхар**213 тоот өрөө, Засварын Алба****Факс 70002292, Утас 70281234.**

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СӨНИН

[МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛААС ЧУХЛЫГ НЬ]

ЗГМ: Сэдэв

Охидыг сэвтээсэн хүчирхийллийн сүүдэр

Хохирогчид сэтгэл гутралын гүн хямралд орж, эрүүл мэндээрээ золиослогддог

Байнгын дарамтад байдаг өсвөр насны охид айдастай, сэтгэл гутралтай, эсрэг хүйсийнхээ хүнтэй харьцах хүсэлгүй болдог тул ирээдүйд ээж, хүний эхнэр болно гэдэг маш хүнд гэж судалгаа хийдэг мэргэжилтнүүд хэлж байлаа. Энэ бол ердөө л захын хоёр жишээ. Алслагдсан аймаг, суманд 20 жил гэр бүлийн хүчирхийлэлд амьдарч байсан эмэгтэйн тухай ч нэгэн шинжээч ярьсан юм.

Ийм төрлийн гэмт хэргийн хохирогчид нь голдуу охид, эмэгтэйчүүд байдаг. Зарим хүний адгууслаг зан даамжрахаараа заналхийлэгч, хүчирхийлэгч болж хувирдаг аж. Тиймээс хуулиар хүлээлгэн шийтгэл чанга байх ёстой гэсэн үгийг ч сэтгэл зүйч, шинжээчид хэлж байсан юм.

Гэр бүлийн хүчирхийлэл хоруу чанартай байдаг. Учир нь хохирогч зөвхөн сэтгэл санаагаар бус эрүүл мэндээрээ хохирдог. Энэ төрлийн хүчирхийлэл нь нэг циклээс эхэлдэг бөгөөд хохирогч байнгын стресс өртөж явсаар эцэстээ гүн хямралд ордог. Тодруулбал, асар их стресс хуримтлагдсаар эцэстээ депресс болж, сэтгэл гутралын гүн хэлбэрт шилждэг байна. Иймээс гэр бүлийн хүчирхийллийг дэлхий нийтэд терроризмоос ч аюултай асуудал гэж үздэг болсон. Хэн нэгний дарамтад 10 жил амьдрахад л ходоодны шарх, элэгний архаг үрэвсэлтэй болдог талаар эмч нар ч хэлж байгаа. Иймээс далд хүчирхийлэл нь эрүүл мэндийн хамгийн том дайсан юм.

ТАВАН ХҮНИЙ АМИНД ХҮРСЭН ХҮЧИРХИЙЛЭЛ

НҮБ-ын Жендерийн хөтөлбөрийн мэргэжилтэн “АНУ-д гэр бүлийн хүчирхийлэлээс болж хүний амь эрсэдсэн тохиолдол бүртгэгдсэн. Гэхдээ хүчирхийлэгчээс болж ямар нэгэн шарх сорвитой болсноос

хохирогч амиа алдаагүй. Олон жил дарамтлуулснаас болж бамбай булчирхай нь томорч даамжран, гүн хордлогод орсноос хохирогч амиа алдсан байсан. Мөн хүүхэд нь ч бамбай булчирхайн хурц хордлоготой болсныг эмч нар хэлсэн. Өндөр хөгжилтэй оронд хүртэл гэр бүлийн хүчирхийлэл дийлдэшгүй асуудал болсны нэг илрэл энэ” хэмээв.

Цагдаагийн байгууллагаас гаргасан статистик мэдээллээр Монгол Улсын хэмжээнд 2017 оны эхний таван сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн 570 тохиолдол бүртгэгджээ. Үүний улмаас 581 иргэн хохирч, таван хүн амиа алдсан байна. Зөвхөн хүчирхийлэл хэр хэмжээгээр гарч байна гэдгийг тандах судалгаа хийдэг ч хэчнээн хүн эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохироод байгааг нарийн судалж гаргасан баримт Монголд байхгүй. Хүчирхийллийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон тухай судалгаа Монголд хамгийн хэрэгтэй байгааг холбогдох мэргэжилтнүүд онцолсон. НҮБ цаашдаа ийм судалгаа хийхээр бэлтгэж буй юм байна. Хэрэв ийм төрлийн судалгаа хийчихвэл манай улсын хувьд нэлээд ноцтой асуудал гарч ирж болзошгүй байгаа юм.

ХУУЛИЙН ЗААЛТ ХҮЧИРХИЙЛЛИЙГ

ХАЗААРЛАЖ ЧАДАХ УУ

Хуулийн байгууллагад нэгэн эмэгтэй ханджээ. Тэрбээр “Манай нөхөр байнга согтууруулах ундаа хэрэглэдэггүй. Нэг удаа архи хэтрүүлэн хэрэглэж ирээд тавгүй байдал үүсгэхэд манай хөрш цагдаа дуудаад өгчихлөө. Гэтэл баривчилж хорихоос гадна торгодог болсон юм байна. Зөрчлийн тухай хуулиар 7-30 хоног баривчлах, шалган шийдвэрлэх хугацаа 14 хоног байхаар заасан гэж цагдаа тайлбарлалаа. Энэ талаар одоо л мэдэж байна.

Ийм удаан хорин гэж бодоогүй. Гомдолгүй болохоор асуудлыг шийдэж өгөө” гэжээ. Бас нэгэн эмэгтэй “Би нэг удаа нөхрөө эрүүлжүүлэхэд өгч байсан. Маргааш нь эрүүлжүүлэх байранд хонуулсны төлбөрийг

би төлсөн. Харин одоо хуулийн шийтгэл чангаараа хорьдог болсон байна. Дээр нь гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол 50 мянган төгрөгөөр торгоно гэсэн заалт байгаа юм билээ. Нөхөр согтуу ирээд агсам тавилаа гэхэд би хуулийн байгууллагад мэдээлээгүй бол 50 мянган төгрөгөөр торгуулах болоод байна. Энэ заалтыг нэг л сайн ойлгохгүй байна” хэмээн яриу. Үнэхээр ч түүн шиг хуулийн заалтыг ойлгохгүй байгаа хүн нэг биш тааралдав. Хэдийгээр Зөрчлийн хуульд гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлээгүй бол торгоно гэж заасан ч хөрш нь гэж тодорхой нэр заагаагүй, эсвэл хохирогч өөрөө мэдээлээгүй бол гэж бас тодорхой тусгаагүй учраас энэхүү бүрхэг заалт ойлгоход хялбар биш байгаа бололтой.


» Хэн нэгний дарамтад 10 жил амьдрахад л ходоодны шарх, элэгний архаг үрэвсэлтэй болдог.

» 2017 оны эхний таван сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн 570 тохиолдол бүртгэгджээ.

» Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хувь хүнийг 50 мянган төгрөгтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн хуулиар бол гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдсэн хүн бүр цагдаад мэдэгдэхгүй өнгөрөх эрхгүй болж байна. Хэрэв мэдээлэхгүй өнгөрвөл 50 мянган төгрөгөөр торгуулах шийтгэлтэй.

Гэхдээ ингэж шийтгэлээ гэдэг хүчирхийллийг хазарлаж, таслан зогсоож чадах, эсэх нь эргэлзээтэй. Уг нь хүчирхийлэл үйлдэгчдийг хуулиар шийтгэж, сануулаа гөх нь хамгийн зөв алхам. Харин хуулийн бүрхэг



Зөрчлийн хуулиар бол гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдсэн хүн бүр цагдаад мэдэгдэхгүй өнгөрөх эрхгүй болж байна.

Б.Ганбаяр / ЗГМ ©

заалтаар бол зарим тохиолдолд хохирогч өөрөө цагдаад мэдэгдээгүйн төлөө торгуулж болзошгүй болох нь. Тиймээс хэн цагдаад мэдээлэх вэ гэдэг заалтыг тодорхой болгох шаардлага тулгарч байна.

Зөрчлийн хууль хэрэгжиж эхлээд сар ч болоогүй байгаа учраас цагдаа нар ч өөрсдөө нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй гэсэн тайлбар өглөө. Аливаа зүйл шинэ дээрээ алдаа оноо нь харагддаг болохоор цаашдаа хуулийн ямар заалтууд болохгүй байгаа нь анзаарагдана гэдгийг хуульчид хэлж байв.

Дийлдэшгүй далд бугшмал үзэгдэл болсон гэр бүлийн хүчирхийлэлтэй хатуу тэмцэхгүй бол охид энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болж, золиослогдсоор байна. Хүчирхийлэл хүчирхийлэгчийг төрүүлдэг гэсэн үг бий. Охид бие махбодь, сэтгэл санааны хохирол амсаад өнгөрдөг бол хөвгүүд тийм биш байдаг аж. Насанд хүрээд заавал хариугаа авна хэмээн өширхөх байдал ажиглагддаг талаар сэтгэл зүйч онцолсон юм.

САНУУЛГА ӨГӨХГҮЙ БОЛ ХҮЧИРХИЙЛЭГЧ ДОГШИРДОГ

Хүчирхийлэгчийг ямар нэгэн байдлаар шийтгэхгүй бол гэмт хэрэг дахин давтагдахад эцэстээ хүний амь хохирох

хэмжээнд хүрдэг байна. Сэтгэл зүйн үүднээс нь авч үзвэл гэмт хэрэг үйлдэгч нь би гэсэн байр сууринаас бүх зүйлд хандаж, бүхнийг эрхшээлдээ оруулж, өөрийн түрэмгийллийг тогтоогоод зогсохгүй өршөөгдөх бүртээ надаас эмээж байна хэмээн ташаа ойлгож улам илүү дарамталдаг болдог байна.

Хүчирхийлэл даамжрахаараа хоруу чанартай болдог

Тиймээс аливаа хүчирхийллийг газар авч, түрэмгийлэгчийг эрхшээлдээ оруулахаас нь өмнө урьдчилан сэргийлэх хэрэгтэй. Гэхдээ хуулиар далайлгахаас

илүү хүчирхийлэл үйлдэгчийг сургалтад хамруулах, сэтгэл заслын эмчилгээнд явуулах гээд олон арга бий. Зарим хүн сургалтад хамрагдаад засардаг. Гэр бүлээ дарамтлахаа больдог. Гэтэл зарим нь заавал хуулийн хариуцлага хүлээж байж дахин гэмт хэрэг хийхгүй болдог онцлогтой гэж хүний эрхийн байгууллагын мэргэжилтэн онцолсон.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй олон жил тэмцэж байж үр дүн гарах байх. Түүнээс одоо бол хүнд байна гэсэн тайлбарыг төрийн бус байгууллагын төлөөлөгчид ярьж байсан. Хорвоод хүн болж төрөөд өсөх бага наснаасаа бусдын эрхэнд орж, бие махбодироо хохирч амьдрах золгүй хувь тавиланг охид амсах учиргүй.

Тиймээс гэр бүлийн хүчирхийллийн эсрэг дуу хоолойгоо нэгтгэмээр байна. [ЗГМ]

ЗГМ:ТОДРУУЛГА

Г.Ганбаясах: Аливаа ял шийтгэл оновчтой байж хууль хэрэгждэг



Бид “Хүйсийн тэгш эрх” төвийн тэргүүн Г.Ганбаясахтай уулзаж, зарим зүйлийг тодрууллаа.

-Танай байгууллагад хүчирхийлэлд өртсөн хүмүүс хэр хандаг вэ?

-Ер нь хүчирхийлэлд өртсөн хүмүүс цөөнгүй ханддаг. Голдуу хойд эцгийнхээ бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид туслалцаа авахаар ирдэг. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг их гардаг боллоо. Үүнээс гадна гэр бүл салалт нэмэгдсэн. -Зөрчлийн хуульд гэр бүлийн хүчирхийллийг мэдээлээгүй бол 50 мянган төгрөгөөр торгоно гэсэн заалт бий. Энэ хэр оновчтой вэ?

-Юуны түрүүнд торгох баривчлахаас илүү хүчирхийлэгчид хариуцлага оногдуулах олон сонголт бий. Эхлээд сайн дураар нь сургалтад хамруулах хуулийн зохицуулалт байгаа. Сайн дураараа сургалтад хамрагдахгүй бол албадан хамруулах заалт бий. Үнэхээр

торгохоос өөр гарцгүй байдаг бол хүчирхийлэгчээс өөрөөс нь торгуулийн мөнгөй авах ёстой. Нөхрөө согтуу ирэхээр цагдаад өгчихдөг. Маргааш нь эхнэр нь өөрөө эрүүлжүүлэхийн мөнгө төлөх хэрэг гардаг. Хүүхдийнхээ хоолноос хэдэн төгрөг хумсалж эрүүлжүүлэхийн төлбөрт өгдөг байсан дээр нь дахиад торгуулийн мөнгө нэмэгдвэл тухайн гэр бүлд хүнд ачаа болох байх. Тэгэхээр хуулийг хэрэгжүүлэхэд ч гэсэн хүндрэл учирч болзошгүй. Аливаа ял шийтгэл оновчтой байж хууль хэрэгждэг. Хууль хяналтын байгууллагынхан гэр бүлийг давхар шийтгэлд унагахгүй байх талаар бодолцох ёстой.

-Хүний наймааны хохирогчид гэр бүлийн хүчирхийллийн золиос болсон байдаг уу, эсвэл өөр шалтгаанаас болдог уу?

-Бид анхандаа гэр бүлийн хүчирхийллийн талаар дагнан ажиллаж байсан. Сүүлийн 10 гаруй жил хүний наймааны хохирогчидтой ажиллаж байна. Янз бүрийн шалтгаан бий. Эдийн засгийн хүнд нөхцөл байдлыг даван туулахын тулд хүний наймааны золиос болдог. Эдийн засгийн хүнд нөхцөлийн шалтгааныг нь судлаад үзэхээр гэр бүлийн хүчирхийлэлд өртөж ийм алхам хийсэн байдаг. Бага насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүмүүс голдуу хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болдог. Манайд хандаж байгаа хүүхдүүдийн 97 хувь нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон байдаг. [ЗГМ]

Шилдгүүдийг нэг дороос...



Та доорх кодыг уншуулж Засгийн Газрын Мэдээ Financial Times сонинг нэг дороос уншина уу



Та QR code уншуулахын тулд App Store-оос QR reader татаж суулгана уу.

70103131, 99903581, 99903584
info@zgsag.gov.mn
ubinfo.mn

МЭДЭЭ
СОНИНГ

FT
FINANCIAL
TIMES

Лавлах

НИЙГЭМ Гүүр барих газрыг чөлөөллөө

Б.Энхжин
ЗГМ

Улаанбаатар хотод БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй эзэлээр гүүрэн байгууламжуудыг шинээр байгуулах, хуучныг нь засах, өргөтгөх төслүүд хэрэгжүүлж эхэлсэн. Тухайлбал, Сонсголлонгийн төмөр бетон гүүрийг шинээр барих төслийн ажил үргэлжилж байна. Уг төслийн хүрээнд газар чөлөөлөх ажлыг нийслэлийн Газрын албанаас гүйцэтгэж дуусчээ. Дөрвөн эгнээ бүхий 289.4 метр урт гүүр барих уг төслийн гүйцэтгэгчээр “Бээжин Юни-Констракшн” групп, туслан гүйцэтгэгчээр “Ган гүүр” ХХК ажиллаж буй.

Сонсголлонгийн шинэ гүүрийг ирэх онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Ингэснээр Нисэх, Яармагийн чиглэл, тухайн чиглэлээс баруун аймгууд руу гарах замын ачаалал багасах ач холбогдолтой юм. [ЗГМ]

ЭРҮҮЛ МЭНД Тарваган тахлын вакцинд хамрагдаарай

ЭМЯ, Зоонозын өвчин судлалын үндэсний төвтэй хамтран тарваган тахлын дархлаажуулалтын аяныг улс орон даяар өрнүүлж байна. Долдугаар сарын 17-нд эхэлсэн вакцинжуулалт ирэх баасан гарагт өндөрлөх юм. Тарваган тахлын вакциныг зургаагаас дээш насныханд хийх заалттай бөгөөд хамрагдахыг хүсвэл харьяа эрүүл мэндийн байгууллагад хандах боломжтой. Тарваган тахлын голомт бүхий хэсэгт амьдардаг иргэд, эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, хууль сахиулах байгууллагын ажилтнууд дархлаажуулалтад хамрагдах шаардлагатайг мэргэжилтнүүд сануулж байна.

Долдугаар сарын 25-ны байдлаар хачгаар дамжих халдварт өвчний нийт 1167 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс (588) 1.9 дахин өндөр байгаа юм. [ЗГМ]

СПОРТ Роналду хамгийн их орлоготой

“Форбес” сэтгүүл дэлхийн хамгийн их орлоготой тамирчдын жагсаалтыг шинэчлэн гаргалаа. Португалын шигшээ болон “Реал Мадрид”-ын од, 2016 оны дэлхийн шилдэг хөлбөмбөгч К.Роналду 93 сая ам.долларын орлогоор жагсаалтыг тэргүүлэв. Сонирхуулахад, эхний 10-т дөрвөн хөлбөмбөгч багтжээ. Энэхүү жагсаалтыг гаргахдаа 2016 оны зургадугаар сараас энэ оны зургадугаар сар хүртэлх хугацаанд олсон орлогыг нь тооцжээ.

1. К.Роналду (хөлбөмбөг) 93 сая
 2. Л.Жеймс (сагсан бөмбөг) 86.2 сая
 3. Л.Месси (хөлбөмбөг) 80 сая
 4. Р.Федерер (теннис) 64 сая
 5. К.Дюрант (сагсан бөмбөг) 60.6 сая
 6. Э.Лак (америк хөлбөмбөг) 50 сая
 7. Р.Макиррой (гольф) 50 сая
 8. С.Корри (сагсан бөмбөг) 47.3 сая
 9. Ж.Харден (сагсан бөмбөг) 46.6 сая
 10. Л.Хэмилтон (авто спорт) 46 сая
- (Ам.доллараар) [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	08.30 Засгийн газрын цаг	07.30 “Амжилтад хязгаар үгүй” нэвтрүүлэг	08.10 “Анхдагчид” хүүхэлдэйн кино	07.50 “Тунгалаг Тамир” УСК 3 дугаар анги
12.00	11.00 “Цаг үе, үзэл бодол” /шууд/	12.00 “Бизнесийн хэмнэл” давталт	11.15 “Харваач” ОАК 7 дугаар анги	12.00 “Он цагийн эрэлчид” ОАК 5, 6 дугаар анги
14.00	13.20 “Цэлмэг” өдрийн хөтөлбөр	14.00 “Эзэнт гүрнийг босгосон нь” нэвтрүүлэг	14.10 “Зөв үнийг таа” шоу нэвтрүүлэг	17.20 “Миний Монголын өв соёл”
18.00	17.40 Зугаатай математик: Гурвалжингийн талбайг олох	17.00 “Bloomberg Surveillance”	18.05 “Бяцхан оцон шувуу Пороро” хүүхэлдэйн кино	19.30 “Ороод гараач” нэвтрүүлэг 14 дүгээр хэсэг
20.00	19.10 Эргэх дөрвөн цаг. Хэнтий аймгаас бэлтгэв	20.00 “Блумбергийн ярилцах цаг” нэвтрүүлэг	20.50 “80 саяын уналт” асуулт хариултын шоу нэвтрүүлэг	20.00 “Би хэн бэ” шоу нэвтрүүлэг
22.00	21.00 “Нээлттэй хэлэлцүүлэг” /шууд/	22.00 “Байршил” нэвтрүүлэг	22.50 “Көсем” ОАК 63 дугаар анги	22.30 “Тэрсүү хөвгүүд” ОАК 2 дугаар бүлэг 8 дугаар анги

ОНЦЛОХ ҮЗВЭР Анхны 3D хүүхэлдэйн кино



“Том-Амжилт” компанийн хамт олон Монголын анхны 3D хүүхэлдэйн кино бүтээж, багачуудын хүртээл болгоход бэлэн болжээ. Тус студийн анхны бүтээл болох “Мора” хүүхэлдэйн кино нь нэг цаг, 15 минут үргэлжлэх бөгөөд ирэх сард нээлтээ хийх юм. Киноны үйл явдлыг товчхон дурдвал, Тэргэл хэмээх өөрөөсөө өөр хүнийг хайрлаж, хүндэлдэггүй зожиг зохион бүтээгч залуу “Мора” гэх нисдэг робот бүтээн. Гэвч зохион бүтээгчийн шинэлэг үйлдлийн системд санаархсан Томоо хорон санаа гаргаж, муу бүхнийг үйлдэнэ. Улмаар “Мора”-гийн үйлдлийн систем алдагдаж, Тэргэлийн дурлалт бүсгүй нь сураггүй алга болсноор киноны үйл явц цааш үргэлжилдэг байна. [ЗГМ]

ҮЗВЭР


RIVER BEACH RESORT
“Усаа хайрлан хамгаалцгаая” уриан дор зохиогдох “Tomogrow” хөгжмийн наадмыг энэ сарын 28-нд зориорой. Энд хүрэлцэн ирснээр гурван өөр орчинд зургаан төрлийн хөгжим сонсох боломжтой. Тасалбарын үнэ 20 мянган төгрөг.

ҮНДЭСНИЙ СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН
“Sunrise 2017 Mongolia” хөгжмийн наадам ирэх сарын 4-нд 20.00 цагт болно. Наадамд “Харанга”, “Гурван охин”, “Нисванис”, “Ресон”, “UFO” хамтлагаас гадна дуучин Б.Амархүү, Б.Тэнүүн нар оролцоно. Тасалбарын үнэ 20 мянган төгрөг.

ФАНТАМ
S.L энтертайментаас “K pop dance” задгай талбайн бүжгийн тэмцээнийг энэ сарын 28-нд 18.00 цагт төлбөргүй зохион байгуулах гэж байна. Энэхүү арга хэмжээ нь АХА, шилдэг бүжгийн хамтлаг шалгаруулах болон оддыг хэн сайн дуурайх вэ зэрэг олон сонирхолтой хөтөлбөртэй аж.

ТЭНГИС КИНО ТЕАТР
Найруулагч Люк Бэссон, “EuropaCorp” продакшны бүтээл “Valerian” зөгнөлт кино энэ сарын 28-нд нээлтээ хийх гэж байна. Кино нийт 130 минут үргэлжилнэ.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



10. Охины хүүхэд
11. Нэгэн төрлийн мэлхий
6. зуун
8. Амьд явбалаас ус ууна
9. Оройтож төрсөн төл
11. Нэгэн төрлийн малгай
12. Баяр баясгалан

ХӨНДЛӨНГӨӨР:

1. Малын толгой шийрээр хийдэг махан бүтээгдэхүүн
5. Дуучдын хоолойны дасгал

Өмнөх дугаарын хариу / 07.25




БОСООГООР:

1. Бүргэдийн зулзага
2. Тэмцээнд ялагчийн шагнал
3. “Их долоо”-гийн нэг улсын Ерөнхий сайд
4. Ардын жүжигчин
4. Долгорсүрэн тоглож, олон улсад үнэлэгдсэн Монгол, Хятадын уран бүтээлчдийн хамтран бүтээсэн кино
7. Хаясан шагай дөрвөн талаараа буугаагүй байдал

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	VII.26	VII.27	VII.28	VII.29	VII.30
	25° / 11° 8 м/с / 7 м/с	29° / 12° 8 м/с / 5 м/с	31° / 17° 9 м/с / 9 м/с	31° / 16° 7 м/с / 6 м/с	33° / 19° 9 м/с / 7 м/с
	Үршинэ	Үрл багасна	Түр зуурын бороотой	Үршинэ	Үрл багасна



ЗГМ: КОМИКС

Mr. Баагийгийн ПАЯН.....

Сэрүүлэг өглөө дуугарах нь яг л буун дуу шиг

Пөөх, тийм үү?

Чи тэгэнгүүт нь босоод харайх уу?

Үгүй ээ, үхцэн юм шиг л хэвтэнэ шүү дээ.

Айн?


OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ [МЭДЭЭ]

NOMADIC COMICS

ТӨВ ЦЭНГЭЛДЭХ ХҮРЭЭЛЭН
Рок, попын одод “Хурд” хамтлагийн санаачилгаар нэгдэж, “Бид эх орондоо хайртай” хандивын тоглолтыг өнөөдөр 18.00 цагаас зохион байгуулах гэж байна. Нийт 180 минут үргэлжлэх тоглолтоос олсон бүх орлогыг ОБЕГ-т онгоц хуудалдан авахад зориулан хандивлах юм. Тасалбарын үнэ 10 мянган төгрөг.



Билгийн тооллын 3
Зуны адаг улаагчин хонь сарын хоёр хар мэнгэтэй хөв бар өдөр.
Үс засуулбал: Эд мал баялаг төгөлдөр болно.
Наран ургах, шингэх: 05.24-20.31
Барилдлага: Үхэх
Шүтэн барилдлага: Авахуй
Суудал: Төмөр

Аргын тооллын долдугаар сарын 26, Буд гараг. Билгийн тооллын 3. Бага морь одтой, хөх бар өдөр.
Өдрийн наран 05.24 цагт мандан, 20.31 цагт жаргана. Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгус муулах, хараал, жатхыг буцаах, амьлуулах, өглөгийн түлэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Золиг гаргах, бумбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогосод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд малтай, баялаг төгс болно.

ГАЛТ ТЭРЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

Москва-УБ	21.35	07.30
УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Эрдэнэт-УБ	19.10	05.48
Замын-Үүд-УБ	17.35	08.55
УБ-Замын-Үүд	17.20	07.05
Сайншанд-УБ	20.25	07.01
УБ-Сайншанд	09.15	19.15

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	06.10	12.00
УБ-Ханбумбат	07.30	08.40
УБ-Токио	07.55	13.40
УБ-Сөүл	08.45	12.50
УБ-Москва	09.15	10.55
Бээжин-УБ	09.30	12.00
Сөүл-УБ	14.20	16.50
Токио-УБ	14.40	19.10
Москва-УБ	19.25	06.35+1
УБ-Бээжин	22.45	01.00+1




ОУВС-гийн ерөнхий эдийн засагч Маурис Обстфельдийн хэлснээр “Өнгөрсөн арван жилд гарсан дэлхийн эдийн засгийн өсөлт нийтийг хамарсан шинжтэй байлаа”.

Шведийн армийн нууц алдагдав

Ричард Милне

Шведийн армийн бие бүрэлдэхүүн болон төлөвлөгөөний талаар нарийн зүйл агуулсан байж болзошгүй мэдээлэл алдагдсаныг Ерөнхий сайд Стефан Ловфен “маш ноцтой явдал” хэмээн буруушаав. Тэрбээр тээврийн агентлагийн ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх чанар муутай хэлцэл Засгийн газрын нууц алдагдах шалтгаан болсныг шүүмжилжээ. Ноён Ловфен даваа гарагт аюулаас хамгаалах албаны дарга болон зэвсэгт хүчний дээд командлагч нартай хамтарсан хэвлэлийн бага хурал дээр “Тээврийн агентлагт болсон явдал бол сүйрэл. Маш ноцтой асуудал. Энэ нь Швед улс болон Шведийн иргэдийг эрсдэлд оруулаа” хэмээн мэдэгдсэн юм.



Энэхүү дуулиан Засгийн газар болон зүүн төвийнхөөс бүрддэг танхимын хэд хэдэн сайдыг суудлаас нь салгаж болзошгүй байна. Сөрөг намууд үл итгэх асуудлыг парламентад хэлэлцэх санал оруулахаа мэдэгдэв. Ноён Ловфен нэгдүгээр сард уг явдлыг анх мэдсэнээ зөвшөөрсөн бол Дотоод хэргийн болон Батлан хамгаалахын сайд нар жил хагасын өмнөөс мэдэж байжээ. Зүүн Европын орны программ хангамжийн ажилтнуудад аюулаас хамгаалах шалгалт яагаад хийгээгүй талаар одоо тодруулж байгаа гэнэ.

Шведийн армийн командлагч Микаэл Биден цэргийн техник болон нууц ажилтнуудын хөдөлгөөний тухай мэдээлэл алдагдсан байж болох эрсдэл буйг хүлээв. Зэвсэгт хүчний төлөөлөгч урьд нь жолоочийн үнэмлэх, бүр нислэгийн хуваарийг хүртэл хариуцдаг ба аюулаас хамгаалах төлөвлөлтийн талаар мэдэж байсныг анхааруулж байжээ. Шведийн нисэгчдийн хаяг, гэмт хэргийн ба сэжигтний бүртгэл гэх мэт мэдээлэл Чех улсад байрладаг мэдээллийн технологийн ажилтнуудад нээлттэй байсныг бичсэн аж.

Аюулаас хамгаалахын нэгэн ажилтан гэрээг ажлыг гаднын ханд өгсөн нь “Улсынхаа түлхүүрийг өгсөнтэй адил” хэмээн уг хайнга явдлыг анх мэдээлсэн Шведийн Dagens Nyheter сонинд ярсан байна. Үл мэдэгдэх шалтгаанаар Тээврийн агентлагийн захирлын грав дахь хүчин Ардчилсан намын тэргүүн Жимми Акессон “Засгийн газар мэдээлэл алдагдаж буй талаар хоёр жилийн турш мэдэж байсан. Бид хариуцлага хүлээлгэхийг шаардаж байна” гэжээ. Сөрөг гол нам болох Модерейтүүдийн удирдагч Кинберг Батра “Засгийн газрын үйл ажиллагаа цөөн хүнд таалагдаж, олон хүнийг түгшээж байна” хэмээв. Тээврийн агентлаг цэргийн техник ба нисэгчдийн бүртгэлийг хариуцдаггүй боловч нийтэд илчлэх ёсгүй зарим нууц мэдээлэл рүү хандах боломжтой байснаа хүлээсэн юм. Гэхдээ энэ нь мэдээллийг буруугаар ашигласан гэсэн үг биш гэв. Мөн энэ хавраас зөвхөн Шведийн аюулаас хамгаалах албаны шалгалтыг давсан ажилтнууд элдгээр мэдээлэлд нэвтрэх эрхтэй болсон гэдэгт итгэж буйгаа илэрхийлжээ.

ОУВС 2017 оны дэлхийн өсөлтийн төлөвийг хэвээр үлдээв

Шон Доннан

АНУ-ын эдийн засгийн хүлээлтээс доогуур өсөлт, Дональд Трампын амлалтын удаашрал болон Их Британийн гацааны улмаас Хятад, евро бүс, Япон дахь өсөлт саарч магадгүйг Олон улсын валютын сан анхааруулав. Гэхдээ тус сан дөрөвдүгээр сард гаргасан дэлхийн өсөлт энэ онд 3.5, ирэх онд 3.6 хувьтай байх таамаг өөрчилсөнгүй. Хүлээлт өөрчлөгдөөгүй энэхүү таамгийн цаана өсөлтийн эх үүсвэрийн байр солигдож буйг ОУВС тэмдэглэв.

Даваа гарагт Вашингтонд үг хэлсэн сангийн гүйцэтгэх захирал Кристин Лагард ирэх арван жилд ОУВС-гийн төв байр Бээжинд шилжиж болзошгүй талаар хошигножээ. Тус байгууллагын дотоод дүрэм ёсоор төв байр нь хамгийн том гишүүн улсад байрлах ёстой ба одоохондоо АНУ хамгийн том хандивлагчийн хувьд ийм шийдвэрт хориг тавих эрхтэйг хатагтай Лагард онцлов. Ноён Трамп Цагаан ордонд ирснээр татварын хэмжээ нэмэгдэж, АНУ-ын ДНБ-д хоёр хувьтай тэнцэх дэмжлэг үзүүлнэ гэж сангийн оны эхний таамагт дурдсан байгаа.

Гэтэл Трампын засаг захиргаа ба конгресс дэх БНН-ын

олонх татварын шинэчлэлийг урагшлуулж чадаагүй. Тиймээс ОУВС АНУ-ын өсөлтийн таамгаа өнгөрсөн сард доошлуулж, энэ онд 2.1-2.3 хувь, ирэх онд 2.5 хувь байхаар тооцлоо.

Баасан гарагт нийтлэгдэх АНУ-ын ДНБ-ий хоёрдугаар улирлын тайланд өсөлт эхний улиралд 1.4 хувь байснаас дээшилсэн үзүүлэлт гарах байх. Гэвч энэ нь АНУ-ын 2017 оны өсөлтийн таамагас доогуур байхыг ОУВС мэдээлэв. Харин хөгжингүй бусад орнуудад өсөлт таамагас дээгүүр байгаа. Энэ талаар “Өнгөрсөн арван жилд гарсан дэлхийн эдийн засгийн өсөлт нийтийг хамарсан шинжтэй байлаа” хэмээн сангийн ерөнхий эдийн засагч Маурис Обстфельд хэлэв.

Тэрбээр улс орнуудын зэрэг өсөлт дэлхийн худалдааг нэмэгдүүлж, энэ онд бараа, үйлчилгээний эргэлтийн нийт хэмжээ дөрвөн хувь өсөх төлөвтэй байгаа нь дөрөвдүгээр сард гарсан ОУВС-гийн таамагас 0.2 хувиар дээшилснийг тэмдэглэжээ. Хэрэв энэ таамаг хэрэгжвэл Трамп нарын протекционист бодлогоос үл харгалзан дэлхийн худалдааны өсөлт эдийн засгийн өсөлтөөс дахин давах шинж ажиглагдаж байна. Ноён Обстфельд “Дэлхийн эдийн засаг өсөж байгаа

эргэлзэх зүйлгүй” хэмээсэн юм.

Хатагтай Лагард хэлсэн үгэндээ дэлхийн өсөлтийн эх сурвалж солигдож АНУ-аас холдож байгааг дурдаад, дэлхийн ДНБ-ий 60 хувь, өсөлтийн 80 хувь нь хөгжиж буй орнуудаас гарал үүсэлтэйг онцлов. Сангийн тайланд Их Британийн энэ оны өсөлтийн таамгийг доошлуулж, 1.7 хувь болгосон хэдий ч Европын бусад хэсэгт хүлээлтээс дээгүүр гарах төлөвтэйг тэмдэглэжээ. Герман болон Францад өсөлт таамагас дээгүүр гарсан тул евро бүсийн нийт өсөлтийн хүлээлт 1.9 хувь хүртэл дээшилснийг ОУВС мэдэгдлээ.

Өнгөрсөн долоо хоногт гарсан тайланд дурдсанаар Хятадын эдийн засгийн өсөлт хоёрдугаар улиралд таамагас дээгүүр гарч энэ онд 6.7 хувь өсөх төлөвтэй боллоо. ОУВС-гийн таамагласнаар 2018 онд өсөлт аажмаар саарч, 6.4 хувьтай байх юм. Тус сан дэлхийн гурав дахь том эдийн засагтай Японы өсөлтийг энэ онд 1.3 хувиар таамагласан боловч дөрөвдүгээр сард уг таамгийг 0.1 хувиар нэмэгдүүлжээ. Ийм өөдрөг хүлээлтийн зэрэгцээ протекционизм зэргээс үүдсэн дэлхийн эдийн засагт урагш дунд хугацааны эрсдэл багасах тийшээ хандсаныг ноён

Обстфельд онцлолоо.

ОУВС-гийн эдийн засагчид тайландаа эдийн засгийн богино хугацааны төлөв сайжирч байгаа хэдий ч урт хугацааны дүр зураг бүдэг хэвээр буйг анхааруулжээ. Тэдний бичсэнээр “Урт хугацааны аажуу өсөлт эрсдэлтэй” бөгөөд хөгжингүй орнуудад орлогын өсөлтийг гацааж, тэгш бус байдлыг нэмэгдүүлж болзошгүй юм. Ноён Обстфельд Бразил, Орос зэрэг шинэ зах зээлүүдэд эдийн засгийн томоохон бэрхшээл тулгарсан хэвээр буйг тэмдэглээд Латин Америкийн орнууд энэ онд болон ирэх жил өмнөх таамагас доогуур өсөлттэй байна гэжээ.

Түүнчлэн ихэнх таваарын үнэ бага зэрэг өөрчлөгдөх төлөвтэй байгаа нь дунд ба доогуур орлоготой орнуудын худалдааны ашигт муугаар нөлөөлж болзошгүйг энд дурдсан байна. Сахараас доошны Африкийн орнуудад өсөлт энэ онд 2.7 хувьтай гарах төлөвтэй байгаа нь өнгөрсөн оныхоос хоёр дахин нэмэгдсэн үзүүлэлт. Гэвч ОУВС-гийн хэлснээр “Энэ өсөлт хүн амын өсөлтөөс үл ялиг дээгүүр байгаа учир нэг хүнд ногдох орлогыг нэмэгдүүлж чадахгүй” аж.



Хималай дахь их гүрнүүдийн маргаан хурцдав

Чарльз Кловвер, Эми Казмин

Азийн хоёр их гүрэн хоёр дахь сардаа сөргөлдөж буй. Хималайн өндөрлөг нутагт Хятадын тал цэрэг, зэвсгийн хүчээ нэмэгдүүлж, газар нутгаа “ямар ч үнээр хамгаална” хэмээн мэдэгдэв. Шинэ Делийн хөрш, холбоотон Бутан болон Бээжингийн хооронд маргаан үүсгэсэн хэдэн зуун метр газрын төлөө Хятад ба Энэтхэгийн хүчин бие биеэ шахахыг оролдож байгаа юм. Энэтхэг улс Бутанд туслахын тулд цэргээ ирүүлж, өөрийн стратегийн ашиг сонирхлыг хамгаалахын сацуу сөргөлдөгч талууд “биеэ барихыг” уриалжээ.

Гэвч Бээжин уг асуудлыг улам хурцатган 1962 онд Энэтхэгийн цэргүүд Хятадын Ардын чөлөөлөх армийг доромжилсон мэтээр дэвэргэн бичсэн байна. 1927 онд Нанкины бослогоор эх үндэс нь тавигдсан ХАЧА-ийн 90 жилийн ойн өмнө Хятадын Батлан хамгаалах яамнаас даваа гарагт гаргасан мэдэгдэлд сүрдүүлсэн шинж агуулагдаж байна. Энд бичихдээ “Хэрвээ Хятадын Ардын чөлөөлөх

армийн 90 жилийн түүх нэг зүйлийг нотолсон бол тэр нь манай тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлаа хамгаалах хүчин чадал улам зузаарч, хөдөлшгүй бэх бат болсон явдал” гэжээ. Цааш нь “Уулыг ганхуулах нь ХАЧА-г ганхуулахаас хялбар” гэсэн байна.

Хималайн өндөрлөг дэх сөргөлдөөн 1962 онд хоёр улсын хооронд болсон хилийн дайнаас хойш хамгийн ноцтой зөрчил боллоо. Тэр үед Хятадын цэргүүд Энэтхэгийн нутгийн гүнд нэвтэрсэн боловч дараа нь цохилтод өртөн ухрахад хүрсэн билээ. Сүүлийн жилүүдэд хоёр улсын хилийн цэргүүд маргаантай бүсэд удаа дараа тулгарч байсан агаад 2014 онд Хятадын цэргүүд Энэтхэгийн гэж үздэг бүс рүү нэвтэрч ороод буцсан нь хамгийн аюултай үйл явдал болсон. Хятадын армийн офицер асан, цэргийн тайлбарлагч Иүз Ган “Байдал маш ноцтой байна. Энэтхэг, Хятадын хооронд болж байсан хорь, гучин жилийн өмнөх мөргөлдөөнөөс шал өөр. Энхийн үйл явц маш удаашралтай

Хятадууд уг замыг тавьснаар цэргийн дэд бүтцээ өргөжүүлж, Энэтхэгийн мужуудыг холбодог зурваст хяналтаа тогтоон заналхийлэх болно гэж Шинэ Дели үзэж байна.



байна” гэжээ.

Зургадугаар сарын 16-нд ХАЧА-ийн барилгын анги Донглан хэмээх бүсэд зам тавьж эхэлснийг Бутаны зүгээс эрс эсэргүүцэн өөрийн нутаг хэмээн зарласны дараа сөргөлдөөн эхэлсэн. Бээжинд албан ёсоор эсэргүүцлээ хүргүүлсэн Бутаны эрх баригчид Шинэ Делигээс тусламж хүссэн гэж Энэтхэгийн

тал тайлбарлаж буй. Улмаар Энэтхэг цэргээ илгээж, зам тавьж буй Хятадын барилгын ангийг ажлаа зогсоохыг шаардсан аж. Хятадууд энэ замыг тавьж цэргийн дэд бүтцээ өргөжүүлэн Энэтхэгийн баруун хойд нутгийг эх газартай холбодог “Тахианы хоолой” хэмээх нарийн хузүүвчид хяналт тогтоон заналхийлэх болно гэж

Шинэ Делийн стратегичид үзэж байна.

Тэд түүнчлэн маргаантай бүс дэх зам нь “Энэтхэгийн аюулгүй байдалд ноцтой нөлөөлж, одоогийн статус квог мэдэгдэхүйц өөрчилнө” гэж мэдэгджээ. Гэвч Хятадын тал ямар нэгэн хэлэлцээ хийж эхлэхээс өмнө Энэтхэгийг уг бүсээс цэргээ гаргахыг

шаардсан боловч Шинэ Дели хүлээн авахаас татгалзсан нь Бээжингийн дургүйцлийг төрүүлээд буй. Хятадын Засгийн газрын China Daily сонины даваа гаргагийн дугаарт “Энэтхэгийн мэдээнээс үзэхэд Донглан дахь цэргүүд урт хугацаагаар үлдэхэд бэлтгэж байна. Гэвч үүнийг зөвшөөрөхгүй” гэж бичсэн байна.



Эдийн засаг

ТҮҮХИЙ ЭД

Эдийн засаг улс төрөөс үл хамааран идэвхжиж байна

Нүүрсний

экспорт

хэлбэлзэлтэй тул

өөдрөг байхаас

зайлсхийх

хэрэгтэй

Б.Мөнхбайгаль
ЗГМ

Эдийн засагч, Ерөнхийлөгчийн орон тооны бус зөвлөх Ч.Отгочулуутай Монгол Улсын эдийн засгийн төлөв байдлын талаар ярилцлаа.

–Оны эхний хагаст эдийн засагт гарсан өөрчлөлтийг хэрхэн дүгнэж байна вэ?

–Статистикаас харахад идэвхжил маш сайн байна. Энэ нь экспортын үндсэн түүхий эд болох зэс, нүүрсний үнэ өсч байгаатай холбоотой. Зөвхөн аж үйлдвэрийн салбарыг харахад 40 орчим хувь буюу хоёр орчим их наяд төгрөгөөр өссөн. Үүнээс үзвэл эдийн засгаа сайн сэргээж чадсан нь харагдаж байна. Урьд нь дан ганц импортын хэмжээ өсдөг байсан бол энэ удаад экспорт ч мөн адил нэмэгдсэн. Тухайлбал, бүтээгдэхүүн үйлдвэрлэл шатахуун, туслах материал зэргийн импорт өссөн. Энэ бол зөвхөн ханшийн зөрүү биш, харин эдийн засгийн идэвхжлийн нэг том илэрхийлэл.

–Эдийн засгийн өсөлтөд ямар хүчин зүйл хамгийн их нөлөөлж байна вэ?

–Гадаад хүчин зүйл түлхүү нөлөөлсөн байна. Ялангуяа, Хятадын зах зээлд зэс, нүүрсний үнэ өсч байгаагаас ихээхэн шалтгаалсан. Олон улсад бас их сонирхолтой нөхцөл байдал үүсээд байгаа. Хориг арга хэмжээний улмаас Хойд Солонгосын экспорт тасалдсан. Нүүрсний экспортод гарч байгаа энэ орон зайг манай компаниуд сайн ашиглаж байгаа. Харин дотоод хүчин зүйл гэвэл, Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор том хөрөнгө оруулалтууд зогсож, хүлээлт үүсгэсэн гэж байгаа ч улс төрөөс хамаарахгүйгээр эдийн засгийн идэвхжил явагдаж байна. Учир нь хүн амын орлогын албан татвар, НӨАТ-ын орлогын хэмжээ төлөвлөснөөс өндөр

гарсан. Өөрөөр хэлбэл, дотоод зах зээлд худалдаа сайн явагдаж байна гэсэн үг. Мөн банкуудын зээлийн үйлчилгээ хэдий асуудалтай байгаа ч зээл олголт, харилцах хадгаламжийн хэмжээ тоон үзүүлэлтээр нэмэгдсэн байна.

–Инфляци өнгөрсөн оныхоос харьцангуй нэмэгдэж байна. Цаашид хэр тогтвортой байх бол?

–Миний хувьд инфляцийн өсөлтийг төдийлэн таашаахгүй байна. Инфляцийн эрүүл өсөлтийн хэмжээ нь 2-4 байх болов уу гэж таамаглаж байгаа. Инфляцийг тэжээж буй гол бодит эх үүсвэр нь мөнгөний нийлүүлэлттэй холбоотой байдаг. Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр хүүхдийн мөнгө гэх зэрэг нийгмийн халамжийн бодлогоор багагүй хэрэгжүүлээ. Үүний үр дагаврыг хэлэх хараахан болоогүй байна. Мөн Засгийн газраас “Приус” машины татварыг нөхөн төлөх шийдвэр гаргасан. Гэвч нэг өссөн үнэ буцаж буух нь хэцүү. Үнэ өссөн шалтгаан нь алга болсон ч үр дагавар нь хэвээр үлддэг муу талтай.

–Оны эхний улирлын дүнгээр эдийн засгийн өсөлт дөрвөөс дээш хувьд хүрч, таамаглаагүй үр дүн гарсан. Таны бодлоор энэ өсөлтөө хэр удаан хадгалж чадах вэ?

–Өсөлтөө хадгална, эсвэл өсөх байх. Өмнө нь хэлсэнчлэн эдийн засгийн 20-30 хувийг эзэлж байгаа том тулгуур болох аж үйлдвэрийн салбарт бараг 40 гаруй хувийн өсөлт гарсан. Тиймээс энэ салбараас шалтгаалан нийт дүнгээрээ өсөх магадлал өндөр.

» Хүн амын орлогын албан татвар, НӨАТ-ын орлогын хэмжээ төлөвлөснөөс өндөр гарлаа.

» БНХАУ зэсийн шинэ эрэлтийн 50 хувийг бүрдүүлнэ.

» Хэтийн төлөвийг харвал 3-5 жилийн дараах зэс, алтны салбар багагүй найдлага төрүүлж буй.

Нүүрсний экспортод гарсан орон зайг манай компаниуд сайн ашиглаж байгаа.



Б.Ганбаяр / ЗГМ

Хөдөө аж ахуйн салбарын хувьд мал сүргийн тоо нэмэгдсэн. Харин ургац хураалтын дүн гарах болоогүй байна. Гэхдээ ган гачиг ихтэй байгаа учраас цаг агаарын байдлаас хамааран оны эцэст энэ дүн буурах магадлал бас бий.

–Нүүрсний экспортын өсөлт анхаарал татаж байна. Цаашид хэр тогтвортой байх бол?

–Мэдээж олон хүчин зүйлээс хамаарна. Хятадын эдийн засгийн өсөлтийн хэмжээ таамаглаж байснаас өндөр гарлаа. Хятадын эдийн засгийн өсөлт, манай нүүрсний экспорт бие биеэ дагадаг. Тиймээс тус улсын эдийн засгийн өсөлт хэр тогтвортой байхаас багагүй хамаарна. Миний хувьд тогтвортой байна гэж таамаглаж байгаа.

Энэ жил Хятадад “Нэг бүс ба нэг зам” төслийн хүрээнд бүтээн байгуулалт их хийгдэж байгаа. Тиймээс Хятадын эдийн засгийн

өсөлтөөс үл хамааран манай нүүрсний экспортыг дэмжинэ. Гэвч нүүрсний экспорт маш их хэлбэлзэлтэй байдаг учир хэт өөдрөг байхаас зайлсхийх хэрэгтэй.

–Нүүрсний зах зээлийг тэлэх боломж хэр байна вэ?

–Хэрэв өөр орон зай бий болгоно гэвэл газрын тосны үнэ өссөн тохиолдолд нүүрснээс түлш гаргах боломжтой. Мөн нүүрсний оронд хий ашиглаж болно. Бусад орнуудын аж үйлдвэржилтийн үед хийг дулаан, цахилгаан гаргахад ашигласан байдаг. Манайд үндсэн зах зээл нь бий болчихвол түүнийг нь хангах нүүрс, метан зэрэг байгаа учраас зах зээлийн боломж асар өндөр. Цаашид ийм байдлаар дотоодын зах зээлийн нөөц бололцоо өсөх болов уу гэж харж байна.

–Манай улс Хятадын хойд

хэсгийн аж үйлдвэр болон гангийн үйлдвэрүүдийн хэрэглээг түлхүү хангаж байна. Эдгээрийн эрэлт богино хугацаандаа ямар байна вэ. Компаниуд өөрсдөө нийлүүлэлтээ нэмэгдүүлэх боломжгүй нь хэр бэрхшээл дагуулж байна вэ?

–Компаниуд нийлүүлэлтээ өсгөхөөс гадна тээвэрлэх чадамжтай. Гол бэрхшээл нь хилийн боомтын нэвтрүүлэх чадварт л байгаа юм. Хятадууд “Нэг бүс ба нэг зам” төсөлдөө маш их хөрөнгө оруулж, том хэмжээний бүтээн байгуулалт эхэлж байна. Үүнийг дагаад ган, нүүрс, зэс, цементийн хэрэглээ өндөр болсон. Тиймээс ойрын хугацаанд гадаад зах зээлд Хятад улсын эрэлтийг өөдрөгөөр харах боломжтой. Гэсэн ч бид өрсөлдөгч орнуудаа мартаж болохгүй. [ЗГМ]

УУЛ УУРХАЙ

Дөрвөн жилд гурван сая тонн



Б.Ганбаяр / ЗГМ

Г.Илч
ЗГМ

“Оюутолгой” компани энэ оны хоёрдугаар улиралд 77.8 сая ам.долларын татвар төлжээ. Мөн дотоодоос 153 сая ам.долларын худалдан авалт хийсэн байна. Тус компани Өмнөговь аймгийн тогтвортой хөгжлийн төслүүдэд 3.1 сая ам.доллар зарцуулжээ. Үүнээс гадна тус аймгаас 44 сая ам.долларын худалдан авалт хийсэн байна.

“Оюутолгой” компанийн олборлосон хүдрийн хэмжээ

нэгдүгээр улирлынхаас 3.5 хувиар өссөн. Харин зэсийн борлуулалт нь 5.6 хувиар буурсан аж. Энэ нь тухайн улиралд баяжмалын хэмжээ бага байсантай холбоотой юм. Компанийн гүйцэтгэх захирал Армандо Торрес “Анхны баяжмалаа экспортлоод дөрөв хүрэхгүй жилийн хугацаа өнгөрч байгаа манай хамт олон гурван сая дахь тонн баяжмалаа тээвэрлэж гайхам амжилт гаргалаа” гэжээ.

Тус компани нэг тонн хүдэр боловсруулахад дэлхийн дундаж болох 1.2 шоо метрээр

маш бага буюу 0.373 шоо метр ус ашиглажээ. Энэ хугацаанд ус дахин ашиглалтын түвшин 88.7 хувьд хүрсэн байна.

Харин хоёрдугаар улирлын алтны борлуулалт өмнөх улирлынхаас 28.1 хувиар бага дүнтэй гарчээ. Энэ нь өмнөх улиралд өнгөрсөн оны эцэст үйлдвэрлэсэн өндөр агуулгатай баяжмалыг борлуулсантай холбоотой юм. “Оюу толгой”-г 2017 онд 130-160 мянган тонн баяжмал дахь зэс, 100-140 мянган унци баяжмал дахь алт үйлдвэрлэнэ хэмээн “Туркойз Хилл” таамаглаж байна. [ЗГМ]

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

“Тахько” ХК 541.1 сая төгрөгийн цэвэр ашиг олов

Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа явуулдаг “Тахько” хувьцаат компани энэ оны II улирлын үйл ажиллагааны тайлангаа гаргав. Тус компани он гарснаас хойш 1.59 тэрбум төгрөгийн орлого олж, 541.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Орлогын үзүүлэлт өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар нэмэгдсэн бол ашгийн хэмжээ 3.4 дахин өсөлттэй гарлаа. Ашиг ийнхүү өсөхөд ерөнхий болон удирд-

лагын зардал 26 хувиар буурч, үйл ажиллагааны бус орлого 100 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн “Мобиком”, “Ньюком Проперти” болон “Скайтел” зэрэг компанийн гол үйлчлүүлэгчид түрээсийн хугацаагаа сунгахаар болоод байгаа юм. Ногдол ашгийн тухайд тус компани 2016 оны санхүүгийн цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 108 төгрөг олгож, хувьцаа эзэмшигчдийн дансанд 115.7 сая төгрөг байршуулжээ.

ЗГМ ТОВЧХОН

» ТҮҮХИЙ ЭД

79.5

Хувь. БНХАУ Хойд Солонгосын нүүрсний нийлүүлэлтэд хориг тавьсан тул Монгол Улсаас урд хөршийг чиглэх нүүрсний экспорт эхний хагас жилд 79.5 хувиар өсөж, 10.4 сая тоннд хүрчээ.

» ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

30

Хувь. Манай улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн 30 хувь нь уул уурхай, 23.8 хувь нь барилга, 18 хувь нь жижиглэн худалдаа, авто засварын үйлчилгээ, 9.8 хувь нь боловсруулах үйлдвэр, 6.5 хувь нь боловсролын салбарт ажиллаж байна.

» НИЙГМИЙН ХАЛАМЖ

52.2

Тэрбум төгрөг. Энэ оны эхний хагас жилд нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 52.2 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 757.8 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт боллоо. Мөн энэ хугацаанд 18 хүртэлх насны 622.1 мянган хүүхдэд 75.9 тэрбум төгрөгийн мөнгөн тэтгэмж олгожээ.

» ЗАМ ТЭЭВЭР

135.7

Тэрбум төгрөг. Агаарын тээврийн салбарын орлого энэ оны эхний хагас жилд 135.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 18.3 тэрбум төгрөгөөр өссөн. Энэ нь өмнөх сараас 6.3 тэрбум төгрөгөөр ахисан дүн.

» АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Манай улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын 41 хувийг БНХАУ, 20.5 хувийг ОХУ, 11.3 хувийг БНСУ, 4.2 хувийг Япон, 3.5 хувийг АНУ, 2.5 хувийг Казахстан, 16.7 хувийг бусад улсын иргэд эзэлжээ.

» НООГДОЛ АШИГ

176.6

Тэрбум төгрөг. “Тавантолгой” компани өнгөрсөн онд нүүрсний борлуулалтаас 176.6 тэрбум төгрөгийн орлого олж, 54.04 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Тус компани цэвэр ашгийнхаа 85 хувийг ногдол ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчиддээ олгохоор шийдвэрлэлээ.

» ДЭЛХИЙ

0.6

Хувь. Евро бүсийн эдийн засгийн өсөлт сүүлийн хагас жилийн хамгийн сул үзүүлэлттэй гарав. Тус бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн улирлын дүнгээр 0.6 хувиар өссөн байна. Энэ нь I улирлын үзүүлэлтээс 0.1 хувиар буурсан үзүүлэлт юм.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2442.68
Евро	2824.99
Япон иен	21.80
ОХУ рубль	40.55
БНХАУ юань	359.17
БНСУ вон	2.17

МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР АМЖИЛТЫН ҮНДЭС

Microsoft Dynamics NAV ERP системийг Монголд

INTER SOLUTIONS MANAGEMENT LLC
УТАС: +976 76009293
support@ism.mn